



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 06 сарын 12 өдөр

Дугаар

8/110.

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ахмад настны чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх, соёлын үйл ажиллагааны зардалд зориулж 1 000 000 (нэг сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Мягмаржав)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ХАТАНБААТАР

БАТЛАВ:
МӨРӨН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Н.ХАТАНБААТАР
2025 оны 06 дугаар сарын 05 өдөр

УДИРДАМЖ

Ахмадын урлагийн наадам зохион байгуулах тухай

2025 оны 06 дугаар сарын 05 өдөр

Цагаантолгой баг

Нэг. Зорилго

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж соёлын орон зайг нэмэгдүүлэх, Соёл урлагийн ажлын цар хүрээг тэлэх, Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт хангах, иргэдийн авъяас чадварыг хөгжүүлэх, багийн иргэдийн эв нэгдлийг бэхжүүлэхэд урлагийн бага наадмын зорилго оршино.

Хоёр. Хугацаа:

Урлагийн бага наадам нь 2025 оны 06 дугаар сарын 16-ны 14 цагт сумын Соёлын төвд үзэгчидтэй зохион байгуулагдана.

Гурав. Хамрах хүрээ:

Урлагийн бага наадамд Зөөлөн, Өлзийт, Бүрээт, Цагаан толгой, Чандган багийн ахмадууд оролцоно.

Дөрөв. Урлагийн наадамд оролцох төрлүүд:

- а/ Ардын дуу /эрэгтэй, эмэгтэй аль нэг нь/
- б/ Бүжиг / гоцлол /
- в/ Хөгжим /үндэсний болон бусад хөгжмийн гоцлол, хамтлаг хөгжмийн аль нэг/
- г/ Харилцаа дуу /Зохиолын дуу/
- д/ Уран уншлага
- е/ Нийтийн дуу

Тав. Зохион: байгуулалт

- Урлагийн бага наадамд багийн ахмадуудыг зохион байгуулж, бэлтгэл хангуулан оролцуулна.

- Урлагийн наадмын бэлтгэлийг соёлын төвөөс гаргасан хуваарийн дагуу хийнэ.

- Хэрэв гаднаас ая, бичлэг хэрэглэж байгаа бол шаардлага хангасан байх ба 06 дугаар сарын 13-нд соёлын төвийн ая бичлэгийн нэгтгэлд өгсөн байна. Хэрэв заасан хугацаанд ая бичлэгээ өгөөгүй тохиолдолд тэмцээний үед тухайн төрлийг оруулахгүйг анхааруулж байна. /1 төхөөрөмжөөс ая панаграммыг явуулна/

-Багийн дарга нар оролцсон техникийн зөвлөгөөнийг 2025 оны 06 дугаар сарын 13-нд 17 цагт Соёлын төвийн даргын өрөөнд хийнэ.

-Наадамд оролцох ахмадуудын мэдүүлгийг 2025 оны 06 дугаар сарын 16-нд 09:00 цагт Соёлын төвд хийнэ.

Зургаа . Шүүн дүгнэх журам

- Багийн хамт олныг цаг хэрхэн барьж буйг харгалзан ерөнхий оноон дээр оноо нэмж өгнө.

- Хувцаслалт, тайзны соёл, болон гүйцэтгэлийг харгалзан 0-5 оноогоор дүгнэнэ

Долоо. Шагнал:

1-р байр 1. Шилжин явах цом, өргөмжлөл мөнгөн шагнал

2-р байр 1. Өргөмжлөл, мөнгөн шагнал

3-р байр 1 Өргөмжлөл, мөнгөн шагнал

Төрөл тус бүрт 1,2,3 дугаар байр эзэлсэн авъяастанд алт, мөнгө, хүрэл гардуулна.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

МӨРӨН СУМЫН СОЁЛЫН ТӨВ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР